



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/151

Хэрлэн сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 01-ийг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, ажлын явц, чанарт хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдэд даалгасугай.

3. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газрын Улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай вакцин, био бэлдмэл, эмийн бодис, урвалж, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ